

## **Компанийн 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан**

Манай компани ноос угаах цех ажиллуулснаар 2016 оны эхний хагас жилийн байдлаар 50.6 сая төгрөг, бусад орлогоор 2.3 сая төгрөг, нийт 52.9 мянган төгрөгний орлого олж үйл ажиллагаагаа явууллаа. Эхний хагас жилийн байдлаар 60.2 сая төгрөгийн зардал гаргаж 7.3 сая төгрөгний алдагдалтай ажиллаа.

Зардлыг нарийвчлан дурьдвал цалин, нийгмийн даатгал 16.4 сая төгрөг, цэвэр бохир усны зардал 5.8 сая төгрөг, цахилгааны зардал 3.8 сая төгрөг, уур болон дулааны зардал 3.7 сая төгрөг, түүхий эд, хангамжийн материал, хөдөлмөр хамгаалалын зардалд 1.5 сая төгрөг, элэгдлийн зардал 24.3 сая төгрөг, засварын зардалд 1.2 сая төгрөг, бичиг хэрэг шуудан холбооны зардалд 0.3 сая төгрөг, газрын төлбөр 1.1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2.1 сая төгрөг зэрэг зардлууд гарсан байна. Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, нярав, 3 манаач гэсэн орон тоотой ажиллаж байна.

Дэлхийн зах зээл дээр малын гаралтай бүтээгдэхүүний үнэ унасан, худалдан авагчгүй болсноос ноос угаах цехээ бүрэн хүчин чадлаар ажиллуулах, орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломжгүй байна. Манай компанийн арьс шир боловсруулах, ноос угаах үйл ажиллагаа 2016 оны 2-р сараас эхлэн зогссон байгаа.

Өөрчлөлт шинэчлэлт хийх эрмэлзэлтэйгээр зах зээлийн хүндрэлтэй нөхцөлд санхүүгийн хүндрэлээс гарахын тулд байгаа нөхцөл бололцоогоо дайчлан ажиллаж байна.